



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар

A/78

Онги

Г 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг
татлага явуулах тухай Г

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны A/545 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагын товчоог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Товчооны дарга С.Болоржаргал (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүдэд: Н.Бадамцэцэг (Эрүүл мэндийн төвийн дарга)
Ш.Ууганбаяр (Хэсгийн мөрдөгч)
Б.Арсланбаатар (ЕБС-ийн захирал)
Н.Баярмаа (Соёлын төвийн эрхлэгч)
О.Дашзэвгэ (Архив , бичиг хэргийн ажилтан)
Г.Пүрэв (Онги багийн засаг дарга)
П.Энхсайхан (Мааньт багийн засаг дарга)
Б.Ган-Оргил (Найз багийн засаг дарга)
Х.Энхтайван (Төгрөг багийн засаг дарга)

2. 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулалтын өндөр түвшинд явуулсугай.

3. Цэрэг татлагын товчоонд даалгах нь:

а) Аймгийн Засаг даргын захирамжийн хугацаанд цэрэг татлагыг зохион байгуулж, хяналтын тоог биелүүлэх,

б) 1973-1997 оны цэргийн албыг ямар нэгэн төрлөөр хаагаагүй залуучуудыг Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйл, 2009 оны УИХ-ын 33 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолын дагуу мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах төлбөрийн хэмжээг тооцож мөнгөн төлбөрийг төлүүлэх;

в) Цэргийн насны залуучуудад “Бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх” талаар авсан арга хэмжээ, сургалт явуулсан тайланг гаргахыг сургуулийн захирлын

албыг түр орлон гүйцэтгэгч (Б.Арсланбаатар), урд онуудад цэрэг татлагын товчоогоор орж өвчний улмаас чөлөөлөгдсөн залуучуудын өвчлөл, тэдгээрийг эрүүлжүүлсэн тухай тайланг хүн тус бүрээр гарган ирүүлэхийг Эрүүл мэндийн төвийн дарга (Н.Бадамцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Багийн Засаг дарга нарт даалгах нь:

а) цэрэг татлагын товчоогоор орох цэргийн насны иргэдэд зарлан дуудах мэдэгдлийг албан ёсоор хургуулэх, тэдгээрийг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах

б) цэрэг татлагын товчоогоор ороогүй цэргийн үүрэгтний шалтгааныг тодруулан хүн нэг тус бүрээр тооцон гаргах

5. Цэрэг татлагын ажилд хяналт тавьж зохион байгуулж ажлын үр дүнг танилцуулан ажиллахыг ЗДТГ-ын дарга (С.Болоржаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЛУВСАНРАГВА

